



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 6 сарын 25 өдөр

Дугаар 252

Улаанбаатар хот

**Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцож,
үнэмлэх олгох тухай**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 74.3 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.9 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 20 дугаар тойрогт “Та бидний эвсэл”-ээс нэр дэвшиж 17034 сонгогчийн санал авсан Сайнхүүгийн Ганбаатарыг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсугай.

2. Сайнхүүгийн Ганбаатарт Монгол Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх олгож, нийтэд мэдээлсүгэй.

ДАРГА *Ч. Содном* Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Ц. Болдсайхан* Ц.БОЛДСАЙХАН



00000832